



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/85

Арвайхээр

**Гамшгаас хамгаалах бэлэн байдлын  
зэргийг өөрчлөх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “б”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/24 дүгээр тушаалын 2.6 заалтыг тус тус үндэслэн Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар хуралдаан, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 06 дугаар хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн II түвшин (шар)-д шилжүүлсүгэй.

2. Дээрх өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн II түвшин (шар)-ийн хугацаанд уралдаан тэмцээн, аялал зугаалга (гэр бүлээс бусад), диско баар, караоке, цахим тоглоомын газар, хүүхдийн тоглоомын төвийн үйл ажиллагаа, өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа, жагсаал, цуглаан зохион байгуулахыг хориглосугай.

3. Энэхүү захирамжийн 2 дугаар зүйлд зааснаас бусад үйл ажиллагааг аймгийн хэмжээнд Коронавируст халдвар (Ковид-19) цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлан 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн зөвшөөрсүгэй.

4. Улаанбаатар хотоос ирэх иргэдийг түргэвчилсэн оношлуураар шинжилгээнд хамруулж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, гэрийн тусгаарлалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат), Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудад давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг баталж, 1, 2, 5, 9, 12 дугаар ангийн сурагчдын давтлагыг 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс танхимаар зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх бэлтгэл ажлыг хангахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн)-т үүрэг болгосугай.

011100190

6.Хүнсний болон, ахуйн хэрэглээний худалдаа үйлчилгээний цэгүүд, төв барааны зах, 24 цагийн зөвшөөрөлтэй дэлгүүр, улсын чанартай авто зам дагуу үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэн ажиллуулах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зөвшөөрсүгэй.

7.Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, худалдаа үйлчилгээний төвүүдийн дотор талын ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийлгэж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Зооноз өвчин судлалын төв (Б.Сүхбаатар), сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

8.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (И.Доржсүрэн)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ